



# БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 он

**БАГАХАНГАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2023.12.11

Багахангай дүүрэг

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
<p align="center"><b>Зорилт 1. 4.3:</b> Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ. 4.3.3: Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.</p>							
1.1	"Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын дэд бүтцийг байгуулна.	Улс, нийслэлийн концесс, төр, хувийн хэвшлийн түншлэл	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Зураг төслийн ажлууд хийгдэж байна.	30 хүртэл	<p>Паркт 3 аж ахуйн нэгж байгууллага нэгжээр орсон бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй "Сарьдаг хангай оргил" ХХК нь БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай 2.7 тэрбум юань мөнгөн дүн бүхий төсөвт өртөгтэй, Кокс эрчим хүчний үйлдвэр барих бүтээн байгуулалтын шав тавих ёслолыг 2023.05.09-ний өдөр зохион байгуулсан.</p> <p>2023.12.11-ний өдрийн байдлаар паркийн 40 га газарт төсөл хэрэгжүүлэгч "Сарьдаг Хангай Оргил" ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын явц 30%-тай байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 1 дүгээр нүүрс буулгалтын конверын ухалт 25м гүнтэй бөгөөд талбайг доторлох ажил явагдаж байна.</li> <li>• Шигшүүрийн, нягтаршуулалтын угсралт хийгдэж, барилгын ажил явагдаж байна.</li> <li>• Төслийн талбайд 20 хятад, 4 монгол иргэн ажиллаж байна.</li> <li>• Ажилчдын байрлах болон үйлчилгээний төвийн барилгын суурийн ажил хийгдэж, дээвэр угсралтын ажил явагдаж байна.</li> <li>• Төслийн талбайд цахилгаан 0.6 кВт түр хэрэглээний дэд станцын аюулгүй байдлыг хангаж хашаажуулсан байна.</li> </ul>	100%

						Мөн төмөр бетон дэр үйлдвэрлэх төслийн "Эл эс рэйлвэйс" ХХК нь паркийн 5 га газарт бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр бэлтгэл ажлаа ханган, түр оффисоо байгуулж, дүүргийн 2 иргэнийг ажлын байраар хангаад байна.	
1.2	"Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийн зураг төслийн ажилд хөрөнгө оруулалт шийдвэрлүүлэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2022 онд 3 зураг төслийн ажил хийгдсэн.	Зураг төслийн ажлын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар санал хүргүүлэх	Нийслэл, дүүргийн удирдлагуудад санал, хүсэлт хүргүүлснээр 2023 онд дараах зураг төслийн ажлууд хийгдсэн. Үүнд: -Багахангай дүүргийн 2023 оны төсвөөс 25 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж паркийн "Хөгжлийн төлөвлөгөө"-ний зураг төслийн ажлыг "ШУҮП холбоо" ТТБ хийж гүйцэтгэн, 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн. -Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжаар 4 зураг төслийн 229 сая төгрөг шийдвэрлэгдэв. -Паркийн Үер, усны байгууламж 34.5, мэдээлэл, холбоо 15.8, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ 10 сая төгрөгийн зураг төслийн ажлыг нийслэлийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлжээр хүлээгдэж байна. <b>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд:</b> -Паркт нэгжээр орсон "Эл эс рэйлвэйс" ХХК нь паркийн хашаажуулалтын зураг төслийн ажлыг 5 сая төгрөгөөр хийсэн. -Паркийн оффисын барилгын зураг төслийн ажил хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна.	100%
1.3	Багахангайн Үйлдвэрлэл, технологийн паркийн Авто замын зураг төслийн ажлын саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	60.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Холбогдох байгууллагад санал хүргүүлэх	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр авто замын зураг төслийн 60 сая төгрөг шийдвэрлэгдэж, дүүргийн Худалдан авах ажиллагааны алба тендер зарлан, "Ихэр мөнх" ХХК шалгарч, гэрээ байгуулсан.	100%
1.4	Багахангайн Үйлдвэрлэл, технологийн паркийн Ус хангамж, ариутгал татуургын зураг төслийн ажлын саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	50.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Холбогдох байгууллагад санал хүргүүлэх	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр паркийн Ус хангамж, ариутгал татуургын зураг төслийн 50 сая төгрөг шийдвэрлэгдэж, дүүргийн Худалдан авах ажиллагааны алба тендер зарлан, "Түмэн амгалан ордон" ХХК шалгарсан.	100%
1.5	Багахангайн Үйлдвэрлэл	-	Хамтран	Техникийн	Зураг	2023 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдөр паркт	100%



	технологийн паркийн 56 га газарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр төмөр зам татах ажлыг судлах, Зураг төслийн ажлыг хувийн хэвшилтэй хамтарч хийх		ажиллах судалгаа хийх	нөхцөл хийгдсэн.	төслийн ажил хийгдэх	нэгжээр орсон "Эл эс рэйлвэйс" ХХК, "Сарьдаг Хангай Оргил" ХХК-ууд Багахангайн төмөр замаас паркийн эзэмшлийн газар хүртэл салаа төмөр зам барих талаар 3 талт уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтаар төр, хувийн хэвшлийн хүрээнд төмөр зам барих, хөрөнгө оруулалт дээр хамтарсан компани байгуулж, салаа төмөр замыг 2024 оны 1 дүгээр улирлаас барьж байгуулахаар хэлэлцлээ.	
1.6	Паркийн эзэмшил 5 га газрыг Нийслэлийн Засаг даргаар батлуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн Засаг даргын захирамж гарсан.	Паркийн эзэмшил газар 5 га-аар нэмэгдэх.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1621 дүгээр захирамжаар газар эзэмших эрх баталгаажсан. Тус захирамжийг үндэслэн нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд гэрээ, гэрчилгээ гаргуулахаар 2023.12.01-ний өдрийн 96 тоот албан бичиг хүргүүлээд байна.	100%
1.7	Паркийн дэд бүтэц байгуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах ажил зохион байгуулах.	-	Хувийн хэвшлийг дэд паркийн бүтцийн ажилд татан оролцуулахад санал тавьж ажиллана.	-	Гадаадын хөрөнгө оруулалтыг татах	2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр "Монгол герман Ханза концерциум групп" ХХК-ийн захирал Н.Баярмаа болон паркид нэгж орсон "Эл эс рэйлвэйс" ХХК-ийн захирал Батбилэгтэй хамтран Багахангай дүүрэгт үйлдвэрлэл, технологийг 14 салбар чиглэлээр солонгосын хөрөнгө оруулалт татах талаар уулзалт хийсэн. Уг уулзалтын хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр дүүрэгт Олон улсын байгууллагын сангийн ерөнхий дэд захирал Kim,sung-kul Солонгосын техник технологи болон дэд бүтэц хөрөнгө оруулалт, урлаг соёлын салбарын зөвлөх, удирдлагууд "Монгол герман "Ханза консорциум групп" ХХК -ны захирал Н.Баярмаа нар хүрэлцэн ирж, үйлдвэрлэл, технологийн 14 салбарын чиглэл, паркийн дэд бүтэц бүтээн байгуулалтын ажилтай танилцсан. Мөн Delphos буюу Олон Улсын Хөрөнгө оруулалтын компанийн захирал Bart Turtelboom-тай хамтран Багахангайн Үйлдвэрлэл Технологийн Паркт хөрөнгө оруулах талаар уулзалт зохион байгуулав.	100%
1.8	Паркт нэгжээр орох хүсэлт өгсөн аж ахуй нэгж байгуулагатай гэрээ байгуулах, ажлыг	-	Гэрээ байгуулж, ажлыг эхлүүлэх	2022 онд 2 ААНБ-тай хамтран ажиллах	Аж ахуй нэгж байгуулагуу д үйл	БҮТПарк нь тусгай зөвшөөрөлийн эрх үүсэх нөхцөл бүрдээгүйгээс аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах боломжгүй. Мөн байгууллагын засаглал өөрчлөгдөж байгаатай холбогдуулан	100%



	эхлүүлэх.			гэрээ байгуулсан.	ажиллагааг аа эхлүүлэх	НИТХ-ын тогтоолоос гарах шийдвэрийг хүлээж байна.	
1.9	Бизнес эрхлэгч нартай "Форум уулзалт зохион байгуулах.	-	ААНБ, иргэдэд үйл ажиллагаагаа танилцуулах	-	Иргэдэд мэдээлэл хүргэх	Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх томоохон бүтээн байгуулалтад гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор НЗДТГ, Улаанбаатар хотын Худалдааны танхим хамтран "Шинэ сэргэлт-Улаанбаатар" уриан дор зохион байгуулагдсан "Улаанбаатар-Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2023"-чуулга уулзалтад Багахангайн үйлдвэрлэл технологийн парк амжилттай оролцлоо. Уг чуулга уулзалтаар 420 орчим гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад төслөө танилцуулж, илтгэл тавин, мэдээ, мэдээлэл хүргэж ажилласан. Мөн 2023.05.26-ны өдөр Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн санаачилгаар Аж үйлдвэржилтийн үндэсний зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Зөвлөгөөний гол зорилго нь салбарын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчин, аж үйлдвэржилтийн сэргэлтэд чухал үүрэгтэй эрчим хүч, дэд бүтцийн нөөц боломж, төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулах зэрэг өргөн хүрээнд тодорхой шийдэл гаргахад чиглэж буй. Аж үйлдвэржилтийн Үндэсний хороо, УУХҮЯ, Уул уурхайн үндэсний ассоциаци, "Эрдэнэс Монгол" нэгдлээс хамтран зохион байгуулж буй тус зөвлөгөөнд дотоод, гадаадын 1000 орчим төлөөлөгч хамт оролцлоо.	100%
1.10	"Багахангайн үйлдвэрлэл технологийн парк"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шил, шилэн бүтээгдэхүүн, барилгын шилэн хийцийн үйлдвэрийг барьж байгуулах, санал санаачилгыг дэмжиж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	"Багахангайн ҮТП-ын хөгжлийн төлөвлөгөө" боловсруулах тендер зарлагдан гэрээ байгуулах шатаандаа байна.	"Багахангайн ҮТП-ын хөгжлийн төлөвлөгөө" -тэй болсон байна. Паркийн дэд бүтцийн шугам сүлжээний зураг төсөв	2020 онд Эрдэс плазм ХХК-нд Шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар дүүрэгт газар олгосон бөгөөд тус компанитай 2021 онд үйл ажиллагааны чиглэлээр уулзалт зохион байгуулж байсан. Тухайн уулзалтаар "Эрдэс плазм" ХХК өөрсдөө Шил, шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн парк байгуулах талаар саналаа илэрхийлсэн.	100%

					боловсруулах ажлын саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх.		
1.1 1	Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичиг болон бусад баримт бичгийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Холбогдох баримт бичгийг бүрдүүлнэ.	Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл хангагдсан. Паркуудын засаглал өөрчлөгдөж байгаатай холбогдуулан НИТХ-ын тогтоолоос гарах шийдвэрийг хүлээж байна.	100%
Зорилт 2.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.							
2.1	Нийслэл, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг нэгтгэн холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Биелэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан.	Өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангах.	Нийслэл, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, байгуулагад хамааралтай ажлыг зохион байгуулан, 2023.11.29-ний өдрийн байдлаар нийт 16 үүрэг даалгаврын биелэлтийг БХДЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.	100%
2.2	Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах.	-	Зохион байгуулсан ажлын тоо	-	2-оос доошгүй ажил зохион байгуулна.	Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд Албан хаагчийг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган дараах ажлыг зохион байгуулав. Үүнд: -“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан сургалт зохион байгуулж, байгууллагын Ёс зүйн дүрэм, журмыг батлуулан, албан хаагчдад танилцуулсан. -“Эерэг харилцаа-Эерэг ажлын байр” уриа дор 1 сарын аяныг зохион байгуулж, албан хаагчдын олонхийн саналаар Угтах үйлчилгээний ажилтан Б.Наранцэцэг шалгарсан.	100%



2.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах	-	Зохион байгуулсан ажлын тоо	“Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” аяны хүрээнд хийсэн ажлын тайланг хүргүүлж ажилласан.	Сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.	“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн талаарх сургалт авах хүсэлтийг дүүргийн Цагдаагийн хэлтэст албан бичиг хүргүүлсний дагуу 2023.04.13-ны өдөр сургалт зохион байгуулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс сэтгэл зүйч Г.Наранбаатартай хамтран зохион байгуулж буй “Тогтвортой гэр бүлийн харилцаа–Тогтвортой амжилтын үндэс” сэдэвт сургалтад хамрагдсан. 2023.09.28-ны өдөр Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Налайх, Багахангай дүүргийн прокурорын газартай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулав.	100%
2.4	Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивт бүрдүүлэлт хийх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Архивт бүрдүүлэлт хийнэ.	Байгууллагын архивын тухай хууль журмыг үндэслэн байгууллагын БНШК-ын хурлаар Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулж, 2022 оны баримтуудын бүрдлийг ханган байнга хадгалах 12, түр хадгалах 16, тусгай төрлийн цаасан суурьтай 3, гэрэл зургийн гэх мэт нийт 32 баримтыг архивт хүлээн авсан. Мөн <a href="https://archiv.ulaanbaatar.mn/">https://archiv.ulaanbaatar.mn/</a> программд байгууллагын даргын А, Б тушаалыг оруулж цахим архив үүсгэв.	100%
2.5	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2022 онд төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан.	Төлөвлөөний дагуу ажил зохион байгуулна.	Албан хаагчийг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 9 заалттай боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
2.6	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр дүүргийн Насан туршийн боловсролын багштай хамтарч “Жендерийн тухай ойлголт” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 8 албан хаагч хамрагдсан. Мөн 2023.11.22-ны өдөр Илч орд ОНӨТҮГ-ын Хөдөлмөр хамгааллын инженер Б.Нямжаргалыг	100%



						урьж, паркийн албан хаагчдад "ХАБЭА-н тухай ойлголт" сэдвээр сургалт зохион байгуулсан.	
2.7	НИТХТ-ийн 2009 оны 63, 2012 оны 61 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах. Жич: Хуваарьт талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, ногоон байгууламжын арчлалт хамгаалалтыг хийх, "Шарилжгүй Улаанбаатар", "Бүх нийтийн их цэвэрлэгээ", "Цас цэвэрлэгээ"-ний ажилд бүрэн хамрагдах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	"Шарилжгүй Улаанбаатар", "Бүх нийтийн их цэвэрлэгээ", "Цас цэвэрлэгээ"-ний ажилд бүрэн хамрагдаж ажилласан.	Тухай бүр албан хаагчдыг бүрэн хамруулна.	Бүх нийтийн их цэвэрлэгээнд 12, цас цэвэрлэгээг 7 удаа зохион байгуулсан. Цэвэрлэгээнд бүх албан хаагчид хамрагдаж байгууллагын ойр орчмын 50 м <sup>2</sup> талбайн хог хаягдлыг цэвэрлэж "Багахангайн тохижилт" ОНӨААТҮГ-аар ачилт хийлгэсэн.	100%
2.8	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд идэвхтэй оролцох, ногоон байгууламжыг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2022 онд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 10 ширхэг мод тарьсан.	Ногоон байгууламжыг нэмэгдүүлнэ.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн хамт олон 2023.05.29-ний өдөр мод тарих арга хэмжээнд оролцож, дүүргийн 1 дүгээр хорооны нуман хаалганы зүүн талд шинээр барьсан ногоон байгууламжийн хашаанд 2 нарс мод тарьсан.	100%
2.9	Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй тайлагнах.	300,900.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	2022 онд өр авлага үүсээгүй болно.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулна.	Байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд сар улирлын хуваарийг батлуулан, эдийн засгийн ангилал тус бүрээр зориулалтын дагуу зарцуулж байна. Жилийн эцсийн байдлаар 300,900.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 300,900.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, өр авлага үүсгээгүй ажиллаж байна.	100%
2.10	Санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээ тайлан, мэдээллийг тухай бүр холбогдох маягтын дагуу гарган, мэдээллийг шилэн дансны сайтад хуулийн хугацаанд байршуулсан байна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүрт мэдээллийг шивж оруулсан.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шинэчлэгдсэн <a href="https://info.shilendans.gov.mn/">https://info.shilendans.gov.mn/</a> сайт болон хуучин <a href="https://old-info.shilendans.gov.mn/">https://old-info.shilendans.gov.mn/</a> сайтад 163 мэдээ, тайланг бэлтгэн хугацаанд нь мэдээлсэн байна. Мөн байгууллагын мэдээллийн самбарт 2023 оны байгууллагын батлагдсан төсөв, тодотгосон төсөв, төсвийн гүйцэтгэлийн сарын	100%

						бүрийн тайланг тогтмол хуулбарлаж байршуулсан.	
2.1 1	Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жил тутамд хийж, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан байгууллагад хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг тухай бүрт данс, бүртгэлд авна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилд хийж ажилласан.	Эд хөрөнгийн тооллого хийнэ.	2023.07.07-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар байгууллагын 2023 оны Эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгуулав. Уг тооллогоор бараа материал, үндсэн хөрөнгийн жагсаалт, эд хөрөнгө хариуцсан албан хаагчдын хөрөнгийн жагсаалтын дагуу тооллогыг нэг бүрчлэн хийсэн бөгөөд дутагдсан, илүүдсэн, эвдэрсэн хөрөнгө байхгүй болно.	100%
<b>Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 3.</b> (НИТХ-ын 2019 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 146 дугаар тогтоол)							
3.1	Парк хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоод, аж ахуй нэгж байгууллага, хувийн хэвшлийн оролцоог ханган ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	ААНБ, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах.	Дүүргийн 1, 2 дугаар хороонд зохион байгуулсан "Иргэдийн нийтийн" хуралд паркт нэгжээр орсон Кокс эрчим хүчний үйлдвэр барих "Сарьдаг Хангай Оргил" ХХК"-н төсөл хөтөлбөрөө иргэдэд 4 удаа танилцуулан, иргэдээс дэмжсэн санал авсан. 2023 онд "Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх" зорилтот жилийн нээлт, "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т 2 удаа зохион байгуулж, Үйлдвэрлэл, технологийн парк болон паркид нэгжээр орсон компаниуд танилцуулга, төлөвлөгөө, хөтөлбөрөө иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад танилцуулан ажилласан.	100%
3.2	Паркийн бүсэд нарийвчилсан судалгаа, дүгнэлт хийж, паркийг байгуулах хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад санал өгч ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Судалгаа хийх.	Дүүргийн төсвөөр Багахангайн Үйлдвэрлэл, технологийн паркийн "Хэсэгчилсэн хөгжлийн төлөвлөгөө" боловсруулах ажлыг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын хавсралт аргачлалын дагуу "Шинжлэх ухаан үйлдвэрлэл" ТББ хийж гүйцэтгэн, 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн.	100%
3.3	Паркийн боловсруулсан төсөл, хөтөлбөрөө нийслэлийн үйлдвэрлэлийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагад танилцуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Хэрэгжилт 100%	НЗДТГ-ын бодлогын хэлтсүүдэд ЗГҮАХ болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд сар бүр нийт 24 удаа тайлагнан ажилласан.	100%
<b>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт 4.</b>							



4.1	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээн ий чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд мөрдөгдөж буй төрийн байгууллагын цахим хуудасны стандарт норм дүрмийг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн <a href="https://bagakhangai-itp.ub.gov.mn/">https://bagakhangai-itp.ub.gov.mn/</a> вэб сайтад жилийн эцсийн байдлаар 75 цаг үеийн мэдээ, мэдээлэл оруулж хандалтын тоо 702 байна. Цахим Фэйсбүүк хаягаар 123 мэдээлэл оруулж нийт лайк 1,795 комментын тоо 304-н хандалттай байна.	100%
4.2	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Ирсэн өргөдөл гомдлын тоо	2022 онд байгууллагад ирсэн 5 өргөдлийг шийдвэрлэсэн.	Нийт ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх	Жилийн эцсийн байдлаар UBERP өргөдөл, гомдлын нэгдсэн системд 6 өргөдөл бүртгэж, явцын тэмдэглэл хөтлөн, бүрэн шийдвэрлэж ажилласан.	100%
Биелэлтийн дундаж хувь							100%

Төлөвлөгөөг хянасан:  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч  
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөөг тайлагнасан:  
“Багахангайн үйлдвэрлэл,  
Технологийн парк” ОНӨТҮГ-ын дарга  
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч


/Х.Нямбаатар/  
(гарын үсэг)

(огноо)

Төсвийн Шууд захирагч

/Ц.Жамбалцэрэн/  
(гарын үсэг)

(огноо)



(огноо)